

БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ОРШИН ТОГТНОХ ҮНДЭС CONCEPT OF THE ORGANIZATION AND BASIS OF ITS ACTIVITY



Б.ОДБААТАР ХСИС-ын Удирдлагын сургуулийн Цагдаагийн удирдлагын профессорын багийн профессор, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

ODBAATAR B. Professor of Senior Executive Institute, Law Enforcement University, Ph.D, Police colonel

Abstract: In article the questions connected with management of the organizations and stages of its development are considered ways of their improvement are offered.

Байгууллага, түүний бүтэц, зохион байгуулалт, оршин тогтнох үндсийн талаар авч үзэхийн тулд юуны өмнө “Байгууллага” гэсэн нэр томъёоноос эхлэх нь зүйтэй юм.

Монгол хэлний тайлбар толь бичигт: “Байгууллага – 1.Албан газар: Захиргааны байгууллага, 2.Төрийн байгууллага, 3.Албан байгууллага” гэж тодорхойлсон байна.

Товчхондоо “байгууллага” гэдэг нь эрхэм зорилго², зорилго³, зорилтууд⁴-аа амжилттай хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулсан, түүндээ хүрэх чин эрмэлзлэл бүхий бүлэг хүмүүсийн нэгдэл юм.

Аливаа “байгууллага” нь бүлэг хүмүүсээс ялгагдахын тулд дараах үндсэн шалгууруудаар хэмжигдэж тодорхойлогддог байна. Үүнд:

1. Хоёр ба түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй байх;
2. Бүлгийн нийт гишүүд өмнөө тавьсан нийтлэг зорилго, зорилтыг хүлээн зөвшөөрсөн, түүндээ хүрэх хүсэл эрмэлзлэлтэй байх;
3. Нэгдмэл нэг удирдлагын дор үйл ажиллагаа явуулах;

4. Байнгын, тасралтгүй үйл ажиллагаа явуулах зэрэг үндсэн шалгуурыг хангасан байхаас гадна түүний мөн чанарыг тодорхойлох дараах элементүүд байдаг байна.

- хөдөлмөрийн ололт, ажлын бүтээмж
- эрх ашиг, сонирхол
- шинжлэх ухааны чадавхи (техник, технологийн ололт дэвшил)
- гадаад орчинтой харьцах харилцаа
- дотоод бүтэц, зохион байгуулалт
- үйл ажиллагааны зохицуулалт (хөдөлмөрийн хуваарилалт)
- хамт олны эв нэгдэл (сэтгэл зүйн уур амьсгал)
- хүний нөөц түүний бодлого, төлөвлөлт (алба хаагч, ажилчдын ажил гүйцэтгэх ур чадвар түүний үнэлгээ гэх мэт)
- хөгжлийн цаашдын хэтийн төлөв зэрэг нь байгууллагын мөн чанарыг тодорхойлж байдаг.

Байгууллагын удирдлага, менежментийн онолын хүрээнд байгууллагыг оршин тогтнох хэлбэрээр нь албан ёсны байгууллага, албан ёсны бус байгууллага гэж ангилдаг.

Албан ёсны байгууллага гэдэг гэж дээрх шаардлагуудыг бүрэн хангасан хуулийн этгээдийг хэлнэ.

Харин албан ёсны бус байгууллага гэдэг нь оршин тогтнох тодорхой хугацаагүй, томилогдсон удирдагчгүй, сайн дурын үндсэн дээр нэгдэж үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн нэгдлийг хэлэх ба

¹ Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011. – 108 дах тал.

² Байгууллагын эрхэм зорилго – тухайн байгууллагын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс ба соёлын өв.

³ Байгууллагын зорилго – түүний хүрэхээр тэмүүлж буй эцсийн үр дүн.

⁴ Байгууллагын зорилтууд – эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тодорхой хугацаа тогтоож, үе шаттайгаар хэрэгжүүлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил.

албан ёсны байгууллагын бүтцэд байж болдог байна.

Байгууллагыг явуулж буй үйл ажиллагааны цар хүрээ, чиглэлээр нь:

- төрийн ба төрийн бус байгууллага
- бизнесийн байгууллага
- шашны байгууллага
- нам, улс төрийн байгууллага
- боловсролын байгууллага гэх мэтээр ангилж болно.

Эрдэмтэн судлаачдын бүтээлээс үзэхэд аливаа байгууллага үүсэл хөгжлийнхөө явцдаа үндсэн дөрвөн үе шатыг туулдаг байна.

1 дүгээр үе. Эхлэлийн буюу үүсэх үе шат: Байгууллагыг шинээр үүсгэн байгуулах, эсвэл хуучин бүтцийг өөрчлөх замаар үйл ажиллагааг нь сайжруулах, шинэчлэх.

2 дугаар үе. Өсөлтийн буюу бэхжих үе шат: Байгууллага өсөлтийн үе шатанд янз бүрийн байдлаар шилждэг байна. Тухайлбал хөрөнгө оруулалт хийж буй байдлаар нь 3 ангилж авч үздэг. Энэ нь:

- Босоо өсөлт (Дотоод нөөц бололцоо, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар өсөж байгаа өсөлт).
- Хөндлөн өсөлт (Техникийн ололтод тулгуурлан технологийн уялдаатай болон уялдаатай бус салбаруудыг өөртөө нэгтгэх өсөлт).
- Өргөжилт (Үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэн олон салбар бүтцийг нэгтгэх, төвлөрөх замаар өсөх өсөлт).

3 дугаар үе. Тогтворжилтын буюу хөгжих үе шат: Энэ үе шатанд тухайн байгууллага хэр удаан оршин байж чадсанаар тухайн байгууллагын менежментийн удирдлагын зөв байдал тодорхойлогдоно. Аливаа байгууллагын эцсийн зорилго нь байгууллагын өсөлт, хөгжлийг тогтвортой байлгах, түүнийг байнга хадгалахад чиглэсэн зөв менежмент, удирдлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд оршдог. Иймээс сайн менежменттэй байгууллага тогтворжилтын үе шатанд удаан оршин тогтнож аливаа эрсдэл, аюулаас өөрийгөө хамгаалах арга тактикаа оновчтой хэрэгжүүлдэг байна.

4 дүгээр үе. Бууралтын буюу уналтын үе шат: Байгууллагын үйл ажиллагаа нь гадаад, дотоод орчны янз бүрийн хүчин зүйлийн нөлөөллөөс болж бууралтын буюу уналтын үе шатанд шилждэг. Тухайлбал:

- Үйл ажиллагаагаа зогсоох;
- Үр ашиг багатай салбарыг бусадтай нэгтгэх, татан буулгах замаар үйл ажиллагааны цар хүрээгээ багасгах;
- Гадаад хөрөнгө оруулалтаа татах;
- Өрсөлдөх чадвар, байр сууриа алдах;

- Байгууллагын удирдлагын үйл ажиллагааны хяналт сулрах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байгууллага дээрхи үе шатанд хүрдэг байна.

Иймд аливаа байгууллагын удирдлагын үйл ажиллагаа нь бодит, идэвхтэй, тасралтгүй, байнгын шинжтэй үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж байж сая амжилтад хүрдэг бөгөөд удирдлагын энэ тэнцвэрт харьцаа алдагдах, сулрах, алдаа дутагдал гарах үед байгууллага удирдлагын үйл ажиллагаа гол зарчим, шугамаасаа хазайж түүний бие даасан байдал, үйл ажиллагааны чадавхид сөргөөр нөлөөлж цаашид түүний оршин тогтнох байр суурьт ч аюул учруулж болохуйц нөхцөл байдал үүсч болох юм. Ер нь байгууллагын үндсэн зорилго нь урт удаан хугацаанд оршин тогтнож, үйл ажиллагаагаа тогтмол, жигд найдвартай, үр ашигтай явуулахад оршдог.

Байгууллагын оршин тогтнох үндэс нь түүний орчин бөгөөд өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлэхэд орчны хүчин зүйлүүд эерэгээр эсвэл сөргөөр нөлөөлж байгааг зайлшгүй судалж түүнтэй ажлын уялдаа холбоогоо зохицуулах шаардлагатай байдаг байна.

Үүнээс дүгнэж үзэхэд байгууллагын орчин гэж юуг хэлэх вэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана.

Тэгвэл байгууллагын орчин гэдэг нь байгууллага оршин тогтноход нөлөөлж байгаа хүчин зүйлс, тэдгээрийн хоорондын харилцан холбоо шүтэлцээг хэлэх бөгөөд нөлөөлөх байдлаар нь шууд нөлөөлөх хүчин зүйл, шууд бус нөлөөлөх хүчин зүйл гэж ангилж болох бөгөөд шууд нөлөөлөх хүчин зүйлийг байгууллагын дотоод орчин харин дам нөлөөлөх хүчин зүйлийн гадаад орчин гэнэ.

Байгууллагын хувьд түүний үйл ажиллагааны эцсийн үр дүнд нөлөөлөх, ямагт анхааралдаа байлгавал зохих дотоод орчны хүчин зүйлд дараах зүйлүүд хамаардаг байна. Үүнд:

1. Эрхэм зорилго
2. Зорилго, зорилт
3. Бүтэц, зохион байгуулалт
4. Байгууллагын нөөц
5. Техник, технологи зэргийг хамруулж үздэг бөгөөд эдгээрийг тус бүрт нь авч үзье.

1. Эрхэм зорилго: Энэ нь тухайн байгууллагын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс ба соёлын өв юм. Байгууллагын удирдлагын гол зорилго нь өөрийн эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон хүмүүсийн хүч, оролцоо, хамтын хүчээр түүндээ хүрэх явдал юм.

Тухайлбал: **Хил хамгаалах байгууллагын эрхэм зорилго нь:**

“Хил хамгаалалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, мэргэжлийн чиг хандлагад нийцүүлж, хил хамгаалалтын чадавхийг дээшлүүлэн, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах” явдал байна.

Тэгвэл **цагдаагийн байгууллагын эрхэм зорилго нь** “Хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах”-д оршиж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрхэм зорилго “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх” явдал байна.

Эндээс дүгнэхэд аливаа байгууллагын эрхэм зорилго нь үнэт зүйл зан заншил, соёл уламжлал зэргээс хамааран урт удаан хугацаанд хадгалагдан зорилго, зорилтуудаар дамжин хэрэгжиж байдаг нь харагдаж байна.

2. Зорилго, зорилт: Байгууллагын зорилго гэдэг нь түүний хүрэхээр тэмүүлж буй эцсийн үр дүн бөгөөд байгууллагын зорилтууд нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тодорхой хугацаа тогтоож, үе шаттайгаар хэрэгжүүлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил юм.

Байгууллагын зорилго, зорилтууд нь дараах үндсэн шинжийг агуулсан байдаг. Үүнд:

1. Хэрэгжүүлж болохуйц, бодитой байх — Realistic
2. Тодорхой байх — Specific
3. Хэмжигдэхүйц байх — Measurable
4. Цаг хугацаатай байх — Time bounded
5. Биелэгдэхүйц байх — Attainable

Аливаа байгууллагын зорилго өөр өөр байдаг. Бизнес эрхэлдэг байгууллагууд ашиг, орлого олохын тулд зах зээлд эзлэх хувийг өсгөх, шинэ бараа бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх, менежерийг бэлтгэх ба сонгох зэрэг чиглэлээр өөрийн зорилго, зорилтоо томьёолдог бол хууль сахиулах чиг үүрэгтэй төрийн тусгай байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлэх, үйл ажиллагаандаа хууль ёс, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, алба хаагчийн мэдлэг, ур чадвар, чадавхийг бэхжүүлэх, тэдний манлайллыг дээшлүүлэхэд чиглүүлж өөрийн үйл ажиллагааны зорилго, зорилтоо тодорхойлдог байна. Тухайлбал,

Хил хамгаалах байгууллага 2014 оны зорилтоо

“Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, офицеруудын манлайллын түвшинг дээшлүүлнэ” гэж тодорхойлсон бол Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага 2014 оны үндсэн зорилтоо “Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Энэ байдлаас дүгнэхэд зорилго, зорилт нь үр ашигт үйл ажиллагаа ба бүтээмж, чанар гэсэн зорилгуудыг тусгаж байдаг байна.

3. Бүтэц, зохион байгуулалт: Байгууллагын бүтэц, зохион байгуулалт гэдэг нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэх хамгийн үр ашигтай, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулагдсан, удирдлагын түвшин болон байгууллагын бүтцийн нэгжүүдийн харилцан ажиллагааны уялдаа холбоог хангаж байгаа хоорондоо харилцан хамаарал бүхий үйл ажиллагааны нэгдлийг бүрдүүлэгч элементүүдийг (хэсэг, бүлэг, тасаг гэх мэт) хэлдэг бөгөөд энэ нь цаг хугацааны болон орон зайн шинж чанарыг өөртөө багтаасан ойлголт юм.

Байгууллага бүр өөр өөрийн өвөрмөц, үйл ажиллагааныхаа онцлогт тохирсон зохион байгуулалтын бүтэцтэй байх бөгөөд түүндээ уялдсан эрх мэдэл, албан тушаалын хэлбэр болох удирдлагын төвшний шатлал, үүрэг функцээрээ ялгаатай нэгж, хэлтэс, салбаруудтай байна.

Харин зохион байгуулалт гэдэг нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хүний нөөц, санхүү төсөв, хөрөнгө, мэдээлэл зэрэг бүхий л нөөцийг оновчтой, зохистой байдлаар нэгтгэн зангидах үйл явцыг хэлэх ба энэ нь бүтцийн нэгж, хэсгүүдийг хамгийн оновчтой үр ашигтай хэлбэрээр хуваах үйл ажиллагаа бөгөөд **зорилгоо биелүүлэх үндсэн нөхцөл** болно.

Байгууллагын бүтцийг бүрдүүлэхэд анхаарах хоёр үндсэн асуудал байдаг. Үүнд:

- Үйл ажиллагааны төрөлжсөн буюу хоорондоо уялдаа холбоо бүхий ажил үүргийн жигд, оновчтой, давхцалдалгүй хуваарилалт. Энэ нь байгууллагын нийт ажлын хэсэг болон тухайн ажлыг бусдаас илүү гүйцэтгэн үр дүнд хүрч чадах авьяас чадвар бүхий мэргэжилтэй хүмүүст даатган өгөх удирдлагын үйл ажиллагаа юм.
- Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээ буюу хяналтын тогтолцоо

Байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хөдөлмөрийн оновчтой хуваарилалтыг хийх нь чухал. Үүний тулд удирдлага ба ажилтан, алба хаагчдын харилцан хамаарал, үүрэг даалгаврын оновчтой хуваарилалт, ажлын ачаалал, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог гэх мэт олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай. Хөдөлмөрийн хуваарилалтыг хөндлөн ба босоо хэлбэрийн гэж ангилна.

Хөндлөн хуваарилалт нь байгууллагын үйл ажиллагааг бүрдүүлэгч хэсгүүдэд хуваах замаар хэрэгждэг бол босоо хуваарилалт нь удирдлагын шатлалыг бий болгодог бөгөөд энэхүү хуваарилалтад тулгуурлан байгууллагын зохион байгуулалтын бүтэц бий болдог байна. Үйл ажиллагааны хуваарилалт (хөдөлмөрийн хуваарилалт) хичнээн тодорхой байх нь удирдлагын оновчтой шийдвэр гаргахад нөлөөлөх хамгийн чухал асуудалд тооцогддог.

Хөдөлмөрийн хэвтээ хуваарийн дагуу байгууллагад нэгж, хэсгүүд үүсч үндсэн хөдөлмөр

явагддаг байна.

Зохион байгуулалтын нэгжүүд нь өөрийн өвөрмөц үйл ажиллагаа зорилго, зорилтуудтай байх бөгөөд байгууллагын эрхэм зорилгод нийцэж зохицсон байх шаардлагатай.

Байгууллагын хөдөлмөрийн хуваарь үндсэндээ хэвтээ байдлаар явагдах бөгөөд харин босоо хөдөлмөрийн хуваарийн дагуу удирдлагын төвшний шатлал бий болж шийдвэр гаргалт, зохицуулалтын үйл ажиллагаа явагддаг. Өөрөөр хэлбэл тэр хүрээнд удирдан зохицуулах үйл ажиллагаа хэрэгждэг.

Хяналтын тогтолцоо нь зохион байгуулалтын нэн чухал хэлбэр бөгөөд нэг удирдах албан тушаалтанд нэлээд олон хүн захирагдаж байвал хяналтын өргөн хүрээтэй гэх ба үүний үр дүнд удирдлагын хөндлөн бүтэц бий болдог.

Харин цөөн хүн захирагдаж байвал олон түвшний бүтэцтэй гэж нэрлэгддэг байна.

Хяналт нь үйл ажиллагаа зохих дүрэм, заавар, журам, стандарт, төлөвлөлтийн дагуу явагдаж байгаа эсэхийг тодорхойлох, алдаа дутагдлыг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бөгөөд энэ нь бүх төвшинг хамаарна.

4. Байгууллагын нөөц. Байгууллага үйл ажиллагаандаа зайлшгүй шаардлагатай материал түүхий эд, санхүү, хөрөнгө, мэдээллийн ба хүний нөөцийг ашигладаг. Материалын нөөцийн тасралтгүй болон найдвартай байдал нь тухайн байгууллагын түнш болох бэлтгэн нийлүүлэгчдээс ихээхэн хамаардаг. Байгууллага үйл ажиллагаагаа амжилттай явуулах, өргөжүүлэхэд санхүүгийн нөөц чухал ач холбогдолтой. Санхүүгийн нөөц болох хөрөнгийг арилжааны банкнаас зээл хэлбэрээр, бонд, хувьцаа гаргах замаар гадаад эх үүсвэрээс эсвэл өөрийн дотоод эх үүсвэрээр бүрдүүлдэг. Байгууллагын амжилтанд нөлөөлдөг олон хүчин зүйлсийн дотроос хүний нөөц гол үүрэг гүйцэтгэдэг. Хөдөлмөрийн бирж, хөдөлмөр зохицуулалтын алба, их дээд сургуулийн төгсөгчид, ажиллах хүч нийлүүлэгч компани гэх мэтийн олон гадаад эх үүсвэрээр ажилчдыг бүрдүүлнэ.

5. Техник, технологи нь байгууллагын дотоодод өөрчлөгдөж байгаа хүчин зүйлийн нэг хэсэг юм.

Технологи⁵ гэдэг нь материал болон хүмүүст хүссэний дагуу өөрчлөлт хувирал оруулахад зайлшгүй шаардагддаг мэргэшсэн дадал, тоног төхөөрөмж, дэд бүтэц, багаж хэрэгсэл болон техникийн шаардлагатай хэмжээний мэдлэгийн хослол юм.

Нийгмийн үйл явцын нөлөөн дор оршиж байгаа ямар ч байгууллагын хувьд гадаад орчны нөлөөллийн тухай асуудал чухал байдаг. Гадаад орчны хүчин зүйл нь нөлөөллийнхөө хувьд шууд болон дам байдлаар байгууллагад үйлчилж байдаг. Иймд нөлөөллийн эрчим, үр дагаварыг байгууллагын

удирдлагууд тооцоолон, хуулийн хүрээнд зохицох болон өөрчлөн явуулах ёстой. Тэгвэл байгууллагын гадаад орчин гэдэг нь системийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа түүний гадна орших элементүүдийн олонлог юм.

Байгууллага нь гадаад орчноос хамаарч байдаг нээлттэй систем бөгөөд гадаад орчноо таниж мэдэхгүйгээр өөрчлөлт шинэчлэлтийг амжилттай хэрэгжүүлж чадахгүй.

Байгууллагын гадаад орчны нөлөөлөлийг түүний түвшингээр нь: микро орчин, макро орчин гэж хоёр ангилж авч үздэг.

Микро орчны хүчин зүйлд хэрэглэгч, нийлүүлэгч өрсөлдөгч, түнш ба зохицуулагч зэргийг хамруулдаг ба харин макро орчинд засгийн газар, соёлын хүчин зүйл, технологи, эдийн засгийн хүчин зүйл, хууль эрх зүйн орчин, олон улсын байдал зэрэг хүчин зүйлүүдийг багтаан авч үздэг байна.

Байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх микро орчны гадаад хүчин зүйлд дараах оролцогчдыг багтаан авч үздэг байна. Үүнд:

1. Зохицуулагч. Энэ нь байгууллагад шууд нөлөө үзүүлж байдаг гадаад хүчин зүйл бөгөөд эдгээрт засгийн газрын тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд: тухайлбал, Төрийн өмчийн хороо, Улсын Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн төв, Эрүүл ахуй халдвар судлалын төв, татварын болон гаалийн байгууллага зэрэг байгууллагуудыг нэрлэж болно. Эдгээр байгууллагаас гаргаж байгаа аливаа шийдвэр нь бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг тул гаргасан шийдвэрт зохицуулж үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай болдог.
2. Нийлүүлэгч мөн байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлдэг ба аливаа байгууллага нийлүүлэгчдээс түүхий эд материал авч, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгож хувиргадаг. Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхийн тулд тухайн байгууллагыг чанартай түүхий эд материалаар хангаж байх найдвартай нийлүүлэгчтэй харилцаа тогтоох нь чухал.
3. Хэрэглэгч бол байгууллагын оршин тогтнох үндсэн нөхцөл юм. Өөрөөр хэлбэл байгууллага өөрийн гэсэн хэрэглэгчдийн тодорхой зорилтод зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хэрэглэгчдийн зан төлөв байнга өөрчлөгдөж байдаг учраас хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг үргэлж судлаж, түүндээ тохирсон үйл ажиллагаа явуулахыг шаарддаг. Аливаа байгууллагын нөөц хязгаарлагдмал байдаг харин хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ хязгааргүй хувьсах шинжтэй байдагт анхаарах нь чухал юм.
4. Өрсөлдөгч. Байгууллага зах зээл дээр олон тооны өрсөлдөгчидтэй зэрэгцэн үйл ажиллагаагаа явуулж

⁵ Технологи гэдэг нь нөгөө утгаараа аливаа зүйлийг хийж гүйцэтгэх талаар хуримтлуулсан туршлага юм.

байдаг бөгөөд зах зээлээ алдахгүй, өрсөлдөөнд тодорхой байр суурь олж авахын тулд зөв менежменттэй ажиллах нь илүү ач холбогдолтой. Байгууллага зах зээлд удаан оршин тогтнохын тулд өрсөлдөгчөө байнга судалж тэдний сул талыг өөрсдийн давуу тал болгон ашиглах нь чухал.

Харин байгууллагын макро орчны гадаад хүчин зүйлд дараах нөхцөл байдлуудыг багтаан авч үздэг байна. Үүнд:

1. Засгийн газар буюу улс төр. Аливаа улс орны засгийн газар улс орны нийт эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн хөгжүүлэхэд бизнесийн бүхий л байгууллагын үйл ажиллагааны өсөлт, амжилтыг шийдвэрлэж байдаг. Тийм учраас байгууллагын үйл ажиллагааг эдийн засаг – нийгмийн хөгжилтэй уялдуулахад тус улсын парламент, засгийн газар онцгой анхаарч, бодлогоор, хуулиар дамжуулан хэрэгжүүлдэг. Эдгээр хуулиуд нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, нийгэм ба бизнесийн үр дүнтэй хамтын ажиллагааг хангах нөхцлийг бий болгоход чиглэгдэнэ. Харин засгийн газраас авч байгаа хязгаарлах арга хэмжээ нь бизнесийн тодорхой үйл ажиллагааны хууль бус үйлдлийг таслан зогсооход нөлөөлдөг байна.
2. Олон улсын байдал. Ихэнх байгууллагын гадаад орчин улс дотроо байдаг. Гэвч глобалчлагдаж байгаа өнөө үед дэлхийд үндэстэн дамнасан корпорациуд ихэсч байна. Эдгээр корпорациуд улс болгонд өөр өөр стратегийг баримтлан ажилладаг. Бизнесийн байгууллага оновчтой стратегийг сонгож үр бүтээлтэй ажиллахын тулд тухайн орны бизнесийн орчинг сайтар судлах хэрэгтэй. Тухайлбал үйл ажиллагаа явуулж буй улс орон бүрийнхээ хууль эрх зүйн орчин, эдийн засаг, улс төрийн байдал зэрэгт сайтар судалгаа хийж, нийгэм соёлын амьдралд нь зохицуулах шаардлагатай болдог ба ийм цагт үр бүтээлтэй ажиллах боломжтой юм.
3. Эдийн засгийн байдал. Дам нөлөөллийн нэг гол зүйл бөгөөд үүнд: үнийн өсөлтийн түвшин,

ажилгүйдлийн төвшин, валютын ханш, зээлийн хүү, улсын төсөв ба худалдааны алдагдал гэх мэт хүчин зүйлүүд байгууллагын үйл ажиллагаанд хүчтэй нөлөө үзүүлдэг. Аливаа байгууллагын удирдлага нийт үйлдвэрлэлд нөлөөлж байгаа эдийн засгийнхаа байдалд дүгнэлт, судалгаа, шинжилгээ хийлгүйгээр амжилттай үйл ажиллагаа явуулах боломжгүй. Тийм учраас аливаа үйл ажиллагааг явуулахын өмнө тухайн орны болон олон улсын эдийн засгийн байдлыг дотоод орчинтой харилцан уялдаатайгаар судлах шаардлага зүй ёсоор гардаг байна.

4. Технологи нь нэг талаас байгууллагын дотоод орчныг тодорхойлж байдаг бол нөгөө талаас нь бас байгууллагын гадаад, дам нөлөөллийн орчныг тодорхойлогч хүчин зүйл болдог. Технологийн хөгжлийг дагаад шинэ орчин, шинэ бүтээгдэхүүн, шинэ чадвар хөгжүүлэх боломж бүрддэг учраас аливаа байгууллага шийдвэр гаргаж, бодлого боловсруулахдаа технологийн хүчин зүйлийг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй.
5. Нийгэм ба соёлын хүчин зүйл. Байгууллагын үйл ажиллагаанд нийгэм соёлын хүчин зүйл байнга нөлөөлдөг учраас энэхүү хүчин зүйлд дасан зохицох хэрэгтэй. Ер нь соёл гэж аливаа тулгамдсан бэрхшээлийг давж, зорилтоо шийдвэрлэхэд боловсрол, шинжлэх ухаан, урлаг, спорт, оюун санаа, амьдралын бүхий л ололт амжилтыг ашиглах чадвар юм.

Энэ бүхнээс дүгнэхэд аливаа байгууллагын оршин тогтнохын үндэс нь өөрийн гадаад орчин, нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаагаа орчны өөрчлөлттэй уялдуулах, зөв бодлого хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь түүний амжилт олох, урт удаан хугацаанд оршин тогтнох чадварын илэрхийлэл юм.